

Curriculum

- Elementary Curriculum:

<http://www.edu.gov.on.ca/eng/curriculum/elementary/>

- Secondary Curriculum:

<http://www.edu.gov.on.ca/eng/curriculum/secondary/index.html>

The American School of Ulaanbaatar offers a dynamic, progressive and balanced academic program in a student-centered learning environment.

From Kindergarten through twelfth grade, the curriculum is both challenging and varied. Our youngest students explore their world and learn to get along with one another through age appropriate activities geared toward preparing them for the more rigorous academic curriculum found in our other divisions. In Elementary, Middle School, High School, the core academic subjects of language arts, mathematics, science, history and social studies, are complimented by a full range of enriching classes in technology, physical education, music, drama and the visual arts.

Pre-Kindergarten: 4 year olds curriculum overview

"Explorer" curriculum

Pre-Kindergarten is a critical time for children as they begin the adventure of a life time of learning. Activities are tailored to meet your child's individual needs and our teachers provide opportunities to explore, question, communicate and create in a fun and supportive environment.

Areas of development

- Language and literacy
- Large motor
- Fine motor
- Mathematics
- Science



The focus this year for your child is kindergarten readiness. All aspects of your child's development continue to shape daily activities, from structured learning in academics and the arts to activities that help build confidence, self-esteem, social and physical skills. Our curriculum continues to focus on developing exceptional math and language skills. Children gain a greater understanding of sequencing and logical problem-solving, providing a strong foundation for advanced math skills. Our excellent language and literacy program promotes a strong understanding of phonics, sentence structure and a heightened vocabulary. Continued development of computer skills enhances the educational and technological experience your child gains.

We continue to stimulate your child's natural curiosity about the world through varying elements of science and social studies through theme-related elements. An appreciation of the arts and music enhances the whole experience at the American School of Ulaanbaatar and instills a love for learning as your child becomes ready to enter kindergarten. With ample

Бага ангийн сургалтын хөтөлбөр

<http://www.edu.gov.on.ca/eng/curriculum/elementary/>

Ахлах ангийн сургалтын хөтөлбөр

<http://www.edu.gov.on.ca/eng/curriculum/secondary/index.html/>

Улаанбаатар дахь Америк сургууль нь сурагч төвтэй сургалтын орчинд динамик, дэвшилтэй, тогтвортой сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

Бид заах арга зүйн хувьд харилцан адилгүй, төрөл бүрийн сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан сурагчдын мэдлэг чадварыг сорьсон сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Манай Бэлтгэл ангийн сурагчид насандаа тохирсон сурах үйл ажиллагааны тусламжтайгаар өөрсдийн ертөнцийг нээж, үе тэнгийн хүүхдүүдийн хамт суралцан анги дээшлэх тусам хүндэрдэг сургалтын хөтөлбөрт бэлтгэгддэг. Бага, Дунд, Ахлах сургуулийн үндсэн хичээлүүд Англи хэл/Уран Зохиол, Математик, Шинжлэх ухаан танин мэдэхүй, Түүх ба Нийгэм судлал зэрэг бөгөөд Мэдээлэл зүй, биеийн тамир, Дуу хөгжим, Жүжиг, болон Зургийн хичээлүүдээр бас ордог.

Цэцэрлэг: 4 настнуудын үзэх хөтөлбөр

"Шинээр нээгч" сургалтын хөтөлбөр

Хүүхдийн хувьд цэцэрлэг бол амьдралын турш сурч боловсрох замын эхлэл юм. Манай сургалтын үйл ажиллагаа таны хүүхдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байдаг. Багш нар сурагчдыг таньж мэдэх, асуух, харилцах, бүтээх боломжийг олгох хөгжилтэй сургалтын орчин бүрдүүлж өгдөг.

Хүүхдэд ямар чадварыг хөгжүүлэх вэ?

- Англи хэл болон үсэг таних
- Биеийн хөдөлгөөнийг хөгжүүлэх
- Жижиг булчингуудын үйл ажиллагаа /гарын булчин гэх мэт/ хөгжүүлэх
- Математик
- Шинжлэх ухаан танин мэдэхүй

Энэ анги таны хүүхдийг Бэлтгэлд ангид бэлдэх зорилготой. Таны хүүхдийг тал бүрээр

хөгжүүлэхийн тулд бид үндсэн хичээлээс эхлэн урлагийн хичээлүүдийг системтэйгээр заахаас гадна хүүхдийг өөртөө итгэлтэй, өөрөөрөө бахархах зэрэг зан чанар хөгжүүлж, хүүхдэд хэрэгтэй дадал чадварыг хөгжүүлнэ. Мөн түүнчлэн тоо, англи хэлний хичээлүүд орно. Тооны хичээлээр сурагч дэс тоо болон энгийн нэмж хасах зэрэг үйлдлүүдийг хийж сурна. Англи хэлний хичээлээр авианы дуудлага болон бичлэг, энгийн өгүүлбэр хэлэх, үгийн сангаа баяжуулах зэрэгт суралцана. Компьюторын хичээлээс олж авсан чадвар нь техник технологитой харьцахад тустай.

Бид хүүхдийн дэлхийн тухай таньж мэдэх төрөлхийн сониуч занг байгаль шинжлэл болон нийгэм судлалын хичээлээр тодорхой сэдвийн дагуу хөгжүүлдэг. Дуу хөгжим, зургийн хичээлээс бүрэн дүүрэн ач тус хүртэх боломжтойгоос гадна цаашид бэлтгэл ангид үргэлжлүүлэн сурах хүсэл, сонирхолтой байдаг. Хүүхдүүдэд тоглох цаг хангалттай байдаг учраас тэд нийгэмших болон биеийн хөдөлгөөний чадвараа сайн хөгжүүлж чаддаг нь бага ангид дэвшин суралцахад бэлтгэдэг.



time given to indoor and outdoor playtime, circle time and free play time your child will have also developed excellent skills in social interaction and physical skills and be ready to enter elementary school with poise and confidence.

Our Pre-Kindergarten (pre-k) program at ASU prepares your child for reading, math, science and much more. Your child needs more than just child care in this critical age.



Kindergarten (children from approximately 5 to 6 years of age)

The program runs for a full day, 8.30 a.m. to 3:20 p.m. Unlike other schools, our Kindergarten is staffed by certified teachers who are qualified to teach up to Grade 3 so that the children are really being prepared for grade one. With a maximum class size of 20, the program consists of a daily program in General Studies, as well as intensive E.S.L.

Our goals are to increase socialization, develop motor skills and early skill and knowledge acquisition through thematic activities in language, science, and numeracy. Music, art and stories are part of a creative developmentally appropriate curriculum. Although socialization outcomes and learning through play are still important, our children take on more responsibility and are expected to meet curricular outcomes in every subject.

Kindergarten is often a child's first introduction to "formal education." Therefore, they are the foundation upon which attitudes towards all subsequent education are built.

We believe that within the mind of every child lie the abilities of an Einstein, a Van Gogh, or a Shakespeare. Finding the keys to unleashing those abilities is one of our fundamental goals. It is thus imperative to provide a program which fosters a sense of enthusiasm towards learning, as well as one which facilitates the development of each individual to his/her fullest potential. Because each child is unique, we recognize that they learn at their own pace and in their own way. Every child's style of learning is identified through close observation, attention to the child's needs, and most importantly, individual time with the teacher.

With supportive guidance, the children are encouraged to experiment, explore, create and problem solve as they play. All activities are designed to intrigue and excite the early learners and allow them to question, investigate and reach conclusions.

The early learning curriculum involves mathematics, reading, written and oral expression, and environmental studies. It also includes activities that develop social, physical, and creative skills.

The classroom environment is positive and stimulating, and whether the children are learning to count, read or paint a "masterpiece," learning is fun! The children soon develop a sense of confidence in their abilities and are ready to take on new challenges. They learn to make decisions and to accept responsibilities.

If, during these most formative years, children build an eagerness to learn and grow in all developmental areas, then the groundwork is set. The children are successfully prepared to take the next step in their education.



Elementary: Grades 1 – 3 (children from approximately 6 to 8 years of age)

As in Kindergarten, the experiences children have in the early primary years continue to mold their attitudes to learning and provide the basic skills and impetus for their continuing education.

The program in the primary grades combines a creative and stimulating, yet structured and disciplined environment, allowing students to grow and develop at their own pace. We strive to provide students with successful experiences which are intended to bolster their self-confidence and self-esteem, and to motivate them to achieve to the best of their abilities.

The curriculum closely follows the Ontario Curriculum guidelines, and stresses the educational basics, building strong foundations in reading, writing, and arithmetic. Using a variety of resources and approaches, the curriculum also includes environmental studies, art,

Манай цэцэрлэгийн хөтөлбөр таны хүүхдийг унших, тоо бодох, байгалийн шинжлэлийн мэдлэгтэй болгохоос илүү зүйлийг зааж өгнө. Яг энэ насны хүүхдэд зөвхөн тэднийг анхаарч халамжлах бус үүнээс ч илүү зүйл хэрэгтэй байдаг.



Бэлтгэл анги (БА) 5-6 настнууд:

Хичээл өглөө 9.00 цагт эхэлж 15.30 цаг хүртэл үргэлжилнэ. Манай бэлтгэл ангид мэргэжлийн дипломтой 3-р анги хүртэл заах чадвартай багш нар хичээл заах учраас хүүхдүүд тань нэгдүгээр ангид элсэн ороход бүрэн бэлтгэгдсэн байдгаараа бусад сургуулиудаас ялгаатай юм. Нэг анги 20 хүүхэдтэй хичээллэх бөгөөд сургалтын хөтөлбөр нь үндсэн хичээлүүдээс гадна англи хэл –хоёрдогч хэл (ESL) -ний эрчимт хөтөлбөрөөс бүрддэг.

Бидний зорилго бол хэл, шинжлэх ухаан болон тооны хичээлээр сэдвийн дагуу төрөл бүрийн сурах үйл ажиллагаагаар дамжуулан нийгэмших чадварыг бий болгох, хөдөлгөөний болон бичих, унших анхан шатны дадал, чадварыг хөгжүүлэх, мэдлэг бүтээхэд оршино. Дуу хөгжим, зураг, уншлагын хичээл нь сурагчдын бүтээлч байдлыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөрийн нэг хэсэг юм. Хэдийгээр хүүхдүүд төрөл бүрийн тоглоом ба үйл ажиллагаагаар дамжуулан суралцаж, нийгэмших чадвартай болох нь чухал боловч тэдэнд илүү хариуцлага хүлээлгэж, бүх хичээл дээрээ сурлагын амжилт гаргахыг бид тэднээс хүсэн хүлээдэг.

Бэлтгэл анги “албан боловсрол” олж авах хамгийн анхны шат болдог. Энэ нь дараагийн шатны боловсрол эзэмших хандлага төлөвших үндсэн суурь болно.

Хүүхэд бүрт Эйнштэйн, Ван Гог, Шекспийр зэрэг алдартай хүмүүсийн нэгэн адил авьяас чадвар нуугдаж байгаа гэдэгт бид итгэлтэй байдаг. Бидний хувьд тэдний энэ авьяас чадварыг нээх түлхүүрийг олох нь гол зорилго юм. Тиймээс хүүхдийн сурах эрмэлзлийг дэмжсэн сургалтын хөтөлбөртэй байх нь зайлшгүй юм. Ингэснээр тухайн хүүхдийн бүхий л чадавхийг нь хөгжүүлэх боломжтой болно.

Хүүхэд бүр өөрийн гэсэн онцлогтой учир тэдний сурах чадвар нь харилцан адилгүй байдаг. Хүүхэд бүрийн сурах арга барилыг тодорхойлохын тулд тэдний хэрэгцээг мэдрэх, ажиглах шаардлагатай боловч багш хүүхэд бүртэй ажиллах цаг гаргах нь хамгийн чухал юм.

Багшийн заавар, дэмжлэгтэйгээр хүүхдүүд тоглохын зэрэгцээ турших, таньж мэдэх, бүтээлчээр сэтгэх, асуудал шийдвэрлэдэг болоход нь багш дэмжин тусалдаг. Манай сургалтын бүхий л үйл ажиллагаа нь бага насны хүүхдийн сонирхолыг татсан, сэтгэл хөдлөлийг дэмжсэн байдаг. Ингэснээр тэд асуулт асуух, судалгаа хийх, дүгнэлт гаргах чадвартай болно.

Бэлтгэл ангийн хөтөлбөрт математик, унших, бичих, ярих, байгаль орчин судлал зэрэг хичээлүүд багтана. Мөн хүүхэд нийгэмших, бие бялдар болон бүтээлч үйл ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтын үйл ажиллагаа олон байдаг.

Манай анги танхим хүүхдийн сурах эрмэлзэл төрүүлсэн сайхан орчинтой. Хүүхдүүд тоо тоолох, унших, зураг зурах зэргийг маш сонирхолтой, хөгжилтэй аргаар сурна. Тэд эдгээр чадваруудыг хурдан эзэмшиж, өөртөө итгэлтэй болж, цаашид илүү шинэ зүйлийг сурч, өөрсдөө шийдвэр гаргах, хариуцлага хүлээх чадварт суралцана.

Бага насанд нь хүүхдэд сурах хүслийг бий болгож, бүх талаар хөгжүүлэн өсгөвөл сурах үндсэн суурь тавигдаж дараагийн шатны боловсрол эзэмшихэд нэг шат ахиж байна.



Бага сургууль: 1 – 3 дугаар анги (6-8 нас)

Энэ насны хүүхдийн хувьд Бэлтгэл ангийн хүүхдийн нэгэн адил бага насандаа олж авсан мэдлэг, туршлага нь тэдний сурах хандлагыг зөв төлөвшүүлсэнээр цаашид суралцах үндсэн дадал чадварыг бий болгоно. Бага ангийн сургалтын хөтөлбөр хүүхдийг бүтээлчээр сэтгэх, тэдний сурах хүслийг

drama, music, and physical education. In all subject areas there is a strong emphasis on creating practical and hands-on activities which enhance the theoretical aspects of the subject. Computers are used as an educational resource, and special events, field trips and extracurricular activities round out the program.

Ongoing assessments allow us to evaluate our teaching and to monitor the academic achievement of our students.. Formal written report cards are issued to parents three times a year with teachers providing anecdotal summaries of individual student achievement. Regular parent-teacher conferences are scheduled to allow for personal insights to be shared.

The school day is from 8:25 to 3:20. Classes are heterogeneous in order for children to be able to learn from and with each other and to support each others strengths. The first 15 minutes of the day is devoted to home room time, with the teacher being the advocate of the children in that class. The limiting class size to a maximum of 24 students allows for the potential of each student to be maximized.

We strive to provide students with successful experiences which are intended to bolster their self confidence and self-esteem, and to motivate them to achieve to the best of their abilities.



Upper Elementary: Grades 4 –5 (children from approximately 8 to 10 years of age)

Children in grade 4 and 5 are entering the important transition years between childhood and preadolescence. Academically, they are consolidating skills acquired at the primary level, while at the same time learning and developing new academic skills and concepts that will prepare them for what lies ahead in middle school and high school.

The program closely follows the Ontario Curriculum guidelines. In addition to the core academic subjects of reading, writing, and arithmetic, the curriculum also includes: science, social studies, Mongolian, art, drama, music, and physical education. A strong emphasis is placed upon organizational skills, research skills, and the development of good work/study habits. Computers are used as an educational resource, and special events, field trips and extra-curricular activities round out the program. The structured program and small class size allow for the potential of each student to be maximized.

Ongoing assessments allow us to evaluate our teaching and to monitor the academic achievement of our students.. Formal written report cards are issued to parents three times a year with teachers providing anecdotal summaries of individual student achievement. Regular parent-teacher conferences are scheduled to allow for personal insights to be shared.

The school day is divided into three parts consisting of: English Language Arts; Mathematics; and Science/Social Studies. Classes are heterogeneous in order for children to be able to learn from and with each other and to support each others strengths. The first 15 minutes of the day is devoted to home room time, with the teacher being the advocate of the children in that class.



Middle School: Grades 6 -8 (children from approximately 10-13 years of age)

At ASU, we understand and support the development and growth that our students are experiencing physically, socially, emotionally and academically. The Middle School is a transition phase that follows a student's journey from childhood towards life as a young adult. This phase demands a special programme, and our curriculum at this stage addresses students' varied levels of emotional, physical, and intellectual development. Subjects are integrated to create rich learning experiences which will enable students to make meaningful links among their topics of study in the classroom and the "real world" beyond the school walls.

Grades 6, 7, and 8 make up our Middle School which is timetabled on a modified rotary basis, Students receive instruction from subject specialists who are able to guide our students in the application of the skills and knowledge they acquired in the lower grades. The core subjects include: Language Arts, Mathematics, Science and Computer Technology,

дэмжсэн байна. Бид зөв зохион байгуулагдсан сургалтын орчинд хүүхдийн сурах арга барилд нь нийцүүлэн өөртөө итгэлтэй, өөрийгөө хүндэтгэдэг, бүхий л чадвараа нээн суралцах боломжоор бүрэн хангана.

Бид Онтарио (Канад)- гийн сургалтын хөтөлбөрийн удирдамжийг чанд баримталдаг бөгөөд унших, бичих, тооны хичээлийн суурийг сайн тавьсанаар цаашид суралцах үндсэн чадварыг эзэмшүүлэхэд бидний зорилго оршино.

Байгаль шинжлэл, Зургийн хичээл, Биеийн тамир, Дууны хичээлүүдийг төрөл бүрийн сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглан заадаг. Тухайн хичээлээр олж авсан онолын мэдлэгээ амьдрал дээр хэрэгж үүлэхэд хүүхэд бүрийн оролцоо маш чухал юм. Тухайлбал компьютер нь сургалтын хэрэглэгдэхүүн юм. Мөн онцлог үйл явдал, хичээлтэй холбогдолтой аялал, хичээлээс гадуур дугуйлан зэрэг нь хөтөлбөрийн нэг хэсэг болдог.

Манай сурагчдаас авдаг явцын шалгалтууд нь бидний хэрхэн зааж байгааг дүгнэхийн зэрэгцээ сурагчдын сурлагын ахицыг хянах боломж олгодог. Бид жилд гурван удаа албан ёсны сурлагын дүнг эцэг эхчүүдэд явуулдаг. Багш нар сурагч бүрийн сурлагын ахиц, амжилтын талаар өөрсдийн дүгнэлтийг бичдэг. Бид эцэг эхийн хурлыг тогтмол зохион байгуулдаг бөгөөд энэ үеэр эцэг эхчүүд өөрсдийн санал бодлоо бидэнтэй хуваалцах боломжтой юм.

Хичээл 8.25 цагаас эхэлж, 15.20 цагт дуусна. Ангид сурах чадвар харилцан адилгүй хүүхдүүд байдаг учир тэд бие биенийгээ дэмжиж, харилцан суралцдаг. Хичээлийн эхний 15 минут тухайн ангид зориулагдсан цаг бөгөөд ангийн багш нь хүүхдүүдээ хэрэгтэй мэдээллээр хангадаг. Нэг ангид байх хүүхдийн тоо 24 байж бөгөөд энэ нь багш хүүхэд бүрт хүрч ажиллах боломжийг бүрдүүлдэг. Бид сурагчдаа өөртөө итгэлтэй, өөрийгөө хүндэтгэдэг болоход нь дэмжин тусалж, өөрийнхөө чадварыг бүрэн дайчлахад бүхий л анхаарлаа хандуулан ажилладаг.



Бага сургууль: (Upper Elementary) 4-5 дугаар анги (8-10 нас)

4 - 5 дугаар ангийн сурагчид хүүхэд наснаас өсвөр нас рүү шилжих эхэн үе бөгөөд маш эмзэг үе юм. Сурлагын хувьд бага ангид эзэмшсэн дадал, чадвараа шинэ мэдлэг, чадвартай хослуулан дунд, ахлах ангид дэвшин суралцахад бэлтгэгднэ.

Манай сургууль Онтариогийн сургалтын хөтөлбөрийг чанд баримталдаг юм. Унших, бичих, тоо зэрэг үндсэн хичээлүүдээс гадна манай сургалтын хөтөлбөрт Шинжлэх ухаан танин мэдэхүйн хичээл, Нийгэм судлал, Монгол хэл, зураг, Жүжгийн хичээл, Дуу хөгжим, Биеийн тамирын хичээл багтдаг. Бид сурагчдыг хувийн зохион байгуулалттай болгох, судалгаа хийж дүн шинжилгээ хийх чадвар эзэмшүүлэх, бие дааж суралцах чадварыг хөгжүүлэхэд түлхүү анхаарч ажилладаг. Тухайлбал компьютер нь сургалтын хэрэглэгдэхүүн юм. Мөн онцлог үйл явдал, хичээлтэй холбогдолтой аялал, хичээлээс гадуур дугуйлангууд нь хөтөлбөрийн нэг хэсэг болдог. Сурагч бүрийн чадварыг хөгжүүлэх нөхцөл байдлыг хангахад тогтсон сургалтын хөтөлбөр, анги дүүргэлтийн тоо чухал байдаг.

Манай сурагчдаас авдаг явцын шалгалтууд нь бидний хэрхэн зааж байгааг дүгнэхийн зэрэгцээ сурагчдын сурлагын ахицыг хянах боломж олгодог. Бид жилд гурван удаа албан ёсны сурлагын дүнг эцэг эхчүүдэд явуулдаг. Багш нар сурагч бүрийн сурлагын ахиц, амжилтын талаар өөрсдийн дүгнэлтийг бичдэг. Бид эцэг эхийн хурлыг тогтмол зохион байгуулдаг бөгөөд энэ үеэр эцэг эхчүүд өөрсдийн санал бодлоо бидэнтэй хуваалцах боломжтой юм.

Хичээлийн нэг өдөр Англи Хэл/УранЗохиол, Математик, Шинжлэх ухаан/Нийгэм судлал гэсэн 3 хэсэгт хуваагддаг. Ангид сурах чадвартай харилцан адилгүй хүүхдүүд байдаг учир тэд бие биенийгээ дэмжиж, харилцан суралцдаг. Хичээлийн эхний 15 минут тухайн ангид зориулагдсан цаг бөгөөд ангийн багш нь хүүхдүүдээ хэрэгтэй мэдээллээр хангадаг.

Social and Environmental Studies, Mongolian, Physical Education, Music, Art and Drama. In addition to the core subjects, the Middle School curriculum features Health and Family Life Education.

Co-curricular activities, community involvement, trips, visitors with expertise and out-of-school programming enrich our curriculum. The Middle School elects its own Student Council which gives students opportunities for leadership and plans special co-curricular programs. Our popular Buddy Program enables a Grade 6 student to partner with a Kindergarten student for a year long classroom program of learning and engaging in activities together guided by their teachers. All of our Middle School subjects are based on Ontario (Canada) Ministry of Education curriculum guidelines so that our graduates are prepared for admission to a variety of international schools.

As students at this stage often become deeply engaged with special interests and pursuits, they have new opportunities to investigate, use and share their growing skills and understandings. Students in the middle school are increasingly able to reflect on their capacities as learners. A strong emphasis is placed on developing an understanding of personal strengths and areas for growth, on building confidence, and skills for leadership. Our holistic approach to education enables students to explore many possible paths to success. This is a time of self-exploration, self-discovery, and a growing understanding of, "Who I am and who I can be."



High School: Grades 9 -12 (children from approximately 14-18 years of age)

At ASU, we understand and support the development and growth that our students are experiencing physically, socially, emotionally and academically. This final stage in our program prepares our students for success in post secondary education and life as an adult. The emphasis for learning and discovery is placed on self exploration and emphasizes personal responsibility, organization, and time management. These students are the leaders and role models within our school's student body. With teacher support they organize large scale events for others students and the wider community.

Our high school program is a four year curriculum after students have successfully completed grade 8 or its equivalent. All students in their first two years of high school will study a full program of eight courses. Successful completion allows students to select a program of studies that meets their individual needs and prepares them for post secondary education. Students select an appropriate combination of academic courses to add to their knowledge and skills base, explore their interests and determine the type of education program they are best suited to undertake in their last two years of high school. In the last two years of high school, students will focus more on their individual interests and identify and prepare for initial postsecondary goals. University and college preparation are designed to equip students with the knowledge and skills they need to meet the entrance requirements for specific university and college programs.

Our program aims at developing healthy, well balanced, and principled young adults. The rigorous curriculum offers opportunities to explore subjects in depth in preparation for success in universities and colleges. A strong emphasis is placed on critical thinking, which develops the ability to appropriately and expertly question established norms and values while developing and questioning our own positions as well. Students are leaders in their own learning, exploring knowledge and reflecting on their context within a specific situation and within the world as a whole. This is a time of independence, leadership and service.

The American International School of Ulaanbaatar is proud to offer a program that is based on the Ontario curriculum that results in students graduating with a diploma that is recognized by universities and colleges in English speaking countries around the world. High standards are expected of graduating students. All graduates must successfully sit the ACT, SAT and/or TOEFL, as well as complete 40 hours of Community Service, in order to earn a diploma from ASU. In addition, the secondary curriculum requires students to develop higher order thinking and learning skills.



Дунд сургууль: 6-8 дугаар анги (10 - 13 нас)

Сургууль дээр сурагчид бие бялдар, нийгэмшил, сэтгэл хөдлөл болон сурлагын хувьд өсөж, хөгжиж байгааг бид ойлгож, дэмжин ажилладаг. Дунд сургуулийн сурагчид хүүхэд наснаасаа бие хүн болон төлөвших шилжилтийн үе дээрээ байдаг. Энэ насны хүүхдэд заах сургалтын хөтөлбөр нь онцлог бөгөөд энэ нь сурах арга барил харилцан адилгүй хүүхдийн сэтгэл санаа, бие бялдар болон оюун ухааны хэрэгцээг хангахад чиглэсэн. Хичээлүүд хоорондоо нягт уялдаа холбоотой байдаг нь тэдэнд амьдралд хэрэгтэй олон зүйлд суралцах боломж олгодог.

Дунд анги 6, 7, 8 дугаар ангиудаас бүрдэнэ. Хичээлүүд нь хуваарийн дагуу ээлжилж орно. Сурагчдын бага ангидаа олж авсан мэдлэг, чадварыг нь амьдрал дээр хэрэгж үзлэхэд шаардлагатай удирдамжийг багшнар нь өгч, удирдан чиглүүлдэг. Хэл уран зохиол, Математик, Шинжлэх Ухаан, Компьютер Технологи, Нийгэм/Байгаль Орчин судлал, Монгол хэл, Биений тамир, Зураг ба Жүжгийн хичээлүүд орно. Бас Эрүүл мэнд ба Гэр бүлийн амьдрал гэсэн сургалтын туслах хөтөлбөрүүд багтана.

Манай сургалтын хөтөлбөрийг төрөл бүрийн туслах хөтөлбөр, нийгэм хамт олны ажил, аялал, алдартай хүмүүсийн лекц, хичээлээс гадуурхи хөтөлбөр зэрэг нь улам баяжуулж байдаг. Дунд анги сурагчдын зөвлөлтэй бөгөөд зөвлөлийн гишүүдээ сонгож ажиллуулдаг. Ингэснээр тэд бусдыгаа манлайлах, янз бүрийн сургалтын туслах хөтөлбөр боловсруулж зохион байгуулах боломжтой. Шинэ сурагчдад туслах хөтөлбөр буюу 6-р ангийн сурагчид Бэлтгэл ангийн сурагчдыг бүтэн хичээлийн жилийн турш даан авч, багшийн удирдлага дор сурах үйл явц болон бусад үйл ажиллагаанд хамтдаа оролцоно. Манай дунд сургуулийн сургалтын агуулга, хөтөлбөр нь Канадын Онтарио мужийн Боловсролын Яамнаас баталсан хөтөлбөртэй бүрэн нийцэж байгаа тул манай төгсөгчид цаашид олон улсын аливаа сургуульд үргэлжлүүлэн суралцах боломжтой юм.

Дунд ангийн сурагчид өөр өөрийн хүсэл, сонирхол, эрмэлзэлтэй учраас өдөр ирэх тусам нэмэгдэж буй мэдлэг, ойлголтоо ашиглан, судалгаа шинжилгээ хийх, бусадтайгаа хуваалцах шинэ шинэ боломжууд гарч ирдэг. Ингэснээр тэд оюуны чадвараа илүү их дайчлан харуулах боломжтой. Бид сурагч бүрийг өөрийн давуу тал, чадавхи таньж мэдэн хөгжүүлж, өөртөө итгэлтэй, манлайлагч сурагч болгон төлөвшүүлэхэд анхаарч ажилладаг. Энэхүү сургалтын цогц арга барил нь сурагч сурлагын амжилт гаргах олон арга замыг өөрсдөө нээн илрүүлэхэд чиглэдэг. Энэ насандаа тэд “Би хэн бэ?” “Би ямар х үн болох вэ?” гэдгээ ойлгож, өөрийгөө нээж, таних нас юм.



Ахлах сургууль 9-12 дугаар анги (14-18 нас)

Сурагчид сургууль дээр бие бялдар, нийгэмшил, сэтгэл санаа болон сурлагын хувьд өсөж, хөгжиж байгааг бид ойлгож, дэмжихийг хүсдэг. Манай сургалтын хөтөлбөрийн сүүлийн үе шат буюу ахлах сургууль нь сурагчдаа ахлах ангид амжилттай суралцаж, бие хүн болж төлөвшин амьдрахад дэмжин туслах зорилготой юм. Сурагч өөрийгөө таньж мэдэх, хариуцлага хүлээх чадвартай, хувийн зохион байгуулалттай, цагаа зөв ашиглаж чаддаг болох нь сурах болон өөрийгөө нээн илрүүлэхийн гол үндэс болно. Ахлах ангийн сурагчид манлайлагч байхын зэрэгцээ бусад сурагчдаа үлгэр жишээ үзүүлэх ёстой. Тэд анги хамт олондоо эсвэл сургуулийн бүх хүүхдэд зориулан олон нийтийг хамарсан арга хэмжээг багш нарын дэмжлэгтэйгээр зохион байгуулдаг.

Манай ахлах ангийн хөтөлбөр нь дөрвөн жилийн хугацаатай бөгөөд дунд сургуулийн 8-р анги буюу түүнтэй ижил түвшний анги төгссөн сурагчид элсэн орж, суралцаж болно. Ахлах сургуулийн эхний хоёр жилд сурагчид нь бүтэн найман курс хөтөлбөрийг дүүргэнэ. Үүнийг амжилттай дүүргэсэн сурагчид нь ЕБС-иа амжилттай төгсөхөд бэлтгэх зорилгоор хувийн хэрэгцээ шаардлагадаа нийцсэн хөтөлбөрийг сонгон авч суралцах боломжтой болно. Өөрөөр хэлбэл сурагчид нь, сүүлчийн хоёр жилд өөрсөддөө хамгийн тохиромжтой, суурь мэдлэг чадвараа нэмэгдүүлэх, цаашид суралцах сонирхол, чиглэлээ нээн илрүүлэхэд шаардлагатай үндсэн хичээлүүдийн хувилбаруудыг эхний хоёр жилд сонгон авах боломжтой юм. Сурагчдыг Их сургууль, коллежийн элсэлтэд бэлтгэхийн гол зорилго нь тухайн сурагч сонгосон сургуулийнхаа элсэлтийн шаардлагад нийцсэн мэдлэг, чадвар эзэмшихэд оршино.

The Ontario system expects that students will be well schooled in the skills necessary for them to take their place as individuals in the global community. The program prepares them to make a living and a life for themselves and to make a difference to others.



Students must successfully complete the following requirements in order to obtain an diploma:

1. Compulsory Credits (18)

- 4 Credits in English (1 credit per grade)
- 3 Credits in Mathematics (at least 1 credit in Gr. 11 or 12)
- 2 Credits in Science
- 1 Credit in History
- 1 Credit in Geography
- 1 Credit in Arts
- 1 Credit in Health and Physical Education
- 0.5 Credit in Civics
- 0.5 Credit in Career Studies
- 1 Credit in a Second Language
- 1 additional credit in English, or English as a Second Language, or Mongolian language, or a classical or an international language, or social sciences and the humanities, or world studies, or guidance and career education.
- 1 Additional Credit in Health and Physical Education, or the Arts, or Business Studies.
- 1 Additional Credit in Science (Grade 11 or 12) or technological education (Grades 9-12).

1. Optional Credits -Any 12 elective Credits may be selected from available courses.
2. Community Service -Completion of 40 hours of community service
3. PLAN, PSAT, SAT and/or ACT – passing score on at least one of these assessments.



COMMUNITY INVOLVEMENT

Students are required to complete 40 hours of community involvement in order to receive a diploma. These activities may be completed at any time during their years in the secondary programme. They may take place in a variety of settings, including businesses, not-for-profit organizations, public sector institutions (including hospitals), and informal settings. The purpose of this requirement is to encourage students to develop an understanding of the various roles they can play in their community and to help them develop a greater sense of belonging within the community. The requirement is to be completed outside students' normal instructional hours -that is, the activities are to take place in students' designated lunch hours, after school, on weekends, or during school holidays. Students may not be paid for performing any community involvement activity.

A "Record of Community Involvement" form must be completed by the student, and signed by the student's parent (if the student is under eighteen years of age), and the community sponsor (the person or organization that provided the community involvement opportunity for the student) and the TAP teacher. Each student will complete a "Tracking Sheet for Community Involvement" at the end of each semester. Students must submit the tracking sheet to the TAP teacher upon completion of the 40 hours or at appropriate intervals determined by the Principal.



STUDENT EVALUATION

Students will be notified, in writing, during the first week of every course, of the method to be used to determine both mid-term and final marks. Term work will make up 70% of the student's mark. This may include tests, projects, activities, presentations, assignments, etc.

Манай сургуулийн хөтөлбөр нь эрүүл чийрэг, төлөвшсөн, зарчимч залуу хүн болгоход чиглэсэн байдаг бөгөөд, их сургууль, коллежид элсэн ороход шаардлагатай бэлтгэлийг тухайн хичээлээр гүнзгийрүүлэн судлах боломжийг сурагчдад олгодог. Бид сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд бүх анхаарлаа хандуулдаг. Ингэснээр тэд өөрсдөө ямар үзэл баримтлалтай байгаагаа шалгаж, улмаар засаж залруулахын зэрэгцээ тогтсон үзэл баримтлалын зөв, буруу эсэхийг өөрсдийн байр сууринаас эргэцүүлэн бодож ялгах чадвараа хөгжүүлнэ. Сурагчид сурах үйл ажиллагаандаа өөрсдөө эзэн нь байж, мэдлэгээ ахиулж, үүнийгээ амьдралдаа тусган харуулж чаддаг болох юм. Ахлах ангид сурагчид биеэ даасан, манлайлагч, бусдад үйлчлэгч гэдгээ харуулах цаг юм. Америк сургууль нь Онтариогийн сургалтын хөтөлбөрт үндэслэн сургалт явуулж, улмаар манай сургуулийг төгсөх сурагчид гадаадын Англи хэлтэй их, дээд сургуулиудад дэвшин суралцахад хүлээн зөвшөөрөгдөх дипломтой төгсөх нь бахархалтай. Төгсөх ангийн сурагчдад маш өндөр шаардлага тавигддаг. Манай төгсөх сурагчид диплом авахын тулд ACT, SAT, TOEFL зэрэг шалгалтуудыг өгсөн байх шаардлагатай бөгөөд олон нийтийн ажилд 40 цаг буюу 1 кредит цуглуулсан байх ёстой юм. Түүнээс гадна ахлах сургуулийн сургалтын хөтөлбөр нь сурагчдаас сэтгэн бодох ба сурах чадварыг өндөр түвшинд эзэмшсэн байхыг шаарддаг.

Онтарио сургалтын хөтөлбөр нь дэлхийн тавцанд бие даасан хүн болон хөл тавихад шаардлагатай чадваруудыг эзэмшүүлэх зорилготой. манай сургалтын хөтөлбөр сурагчдаа амьдралдаа хөлөө олох мөн бусдын амьдралыг өөрчлөхөд бэлтгэнэ.



Сурагчид диплом авахын тулд дараах шаардлагыг биелүүлсэн байх ёстой:

1. Авах ёстой кредит

- 4 кредит – Англи хэл (1 кредит -1 жил)
 - 3 кредит – Математик (болж өгвөл 1 кредит - 11-р эсвэл 12 –р ангид)
 - 2 кредит - Шинжлэх Ухаан Танин мэдэх үйн (1 кредит -1 жил)
 - 1 кредит - Түүх
 - 1 кредит - Газарзүй
 - 1 кредит - Зураг
 - 1 кредит – Эрүүл мэнд ба Биеийн тамир
 - 1 кредит – Иргэний эрх зүй
 - 1 кредит – Мэргэжил судлал
 - 1 кредит – Гадаад хэл
 - 1 нэмэлт кредит – Англи хэл, Англи хэл хоёрдогч хэл, Монгол хэл, Олон улсын хэл, байгалийн шинжлэх ухаан, хүмүүнлэг, дэлхий судлал, мэргэжил судлал зэрэг хичээлүүдийн аль нэгийг сонгон суралцах
 - 1 нэмэлт кредит – Эрүүл мэнд ба Биеийн тамир, Зураг, эсвэл Бизнес судлал
 - 1 нэмэлт кредит – Шинжлэх ухаан (11-р эсвэл 12-р анги) Мэдээлэл зүй (9-12 анги)
2. Сонгон суралцахын кредит – санал болгох 12 сонгон суралцах хичээлээс сонгох
 3. Олон нийтийн ажил – 40 цаг хийх
 4. PLAN, PSAT, SAT эсвэл ACT – гэсэн шалгалтуудын аль нэг дээр тэнцсэн оноо авах



Олон нийтийн ажил

Ахлах ангийн сурагч төгсөх диплом авахын тулд олон нийтийн ажилд оролцож 40 цаг зарцуулсан байх шаардлагатай. Тийм учраас дунд ангид суралцах хугацаандаа янз бүрийн үйл ажиллагаанд оролцож цагаа хийх боломжтой. Хаана ажиллах вэ? Бизнесийн байгууллага, ашгийн бус байгууллага, эмнэлэг мэтийн нийтийн газар, эсвэл албан бус газрууд байж болно. Энэ арга хэмжээний гол зорилго бол сурагчид нийгэмд олон янзын ажил хийх боломжтой гэдгийг ойлгуулах, нийгэмийн нэг хэсэг гэдгийг ухамсарлан ойлгуулахад чиглэнэ. Энэ 40 цагаа хэзээ хийх вэ гэвэл хичээлийн бус цагаар



Examinations/Final Evaluations

- A common examination/evaluation approved by the Principal will be administered in each subject.
- This final evaluation will be 30% of the student's mark and will cover the semester's work.



Equivalent Credits

Students who transfer to ASU from another school are granted equivalent credits based on:

1. The Principal's evaluation of previous academic reports
2. Placement tests
3. Age

Transfer credits are recorded on the transcripts as "Equivalent Credits" for the course title and "EQV" as the percentage earned.



HOMEWORK

Homework assignments are used to reinforce new concepts and skills and to help build desirable work and study habits. The amount of time that students spend doing homework will vary somewhat from day to day, with the ability and diligence of the individual learner and a student's programme and grade level. We ask that parents give support and encouragement for their child in developing good work and study habits by:

- Talking with your child about what she/he is learning
- Establishing a specific nightly homework period
- Providing a quiet place to study
- Being available to answer questions

буюу их завсарлагаа, хичээлийн дараа, амралтын өдрүүд, зуны амралтын үеэр байж болно. Тэд олон нийтийн ажилд оролцсоор цалин авахгүй.

“Олон нийтийн ажилд оролцсон тайлан” -гийн маягтыг сурагч бөглөөд Эцэг/Эх (18 нас хүрээгүй бол), ажил олгогч (олон нийтийн ажил хийх боломж олгосон албан газар, аж ахуйн нэгж), удирдсан багш зэрэг хүмүүсийн гарын үсгийг авна. Сурагч хагас жил бүрийн эцэст” Олон нийтийн ажилд оролцсон цагийн хуудас” бөглөнө. Тэрээр 40 цагаа бүрэн хийсний дараа удирдах багшдаа өгөх эсвэл Хичээлийн Эрхлэгчийн зааврын дагуу тодорхой хугацаанд авчирч өгөх ёстой.



Сурагчдын Үнэлгээ

Хичээлийн эхний долоо хоногт багш нар хичээл дунд болон сүүлд хэрхэн дүгнэх аргыг бичгээр сурагчдад тараана. Сурагчийн дүнгийн 70% нь тухайн улирлын турш хийсэн ажлын үр дүн бөгөөд үүнд шалгалт, төсөл, ангийн ажил, илтгэл, болон даалгаврууд орно.



Шалгалт/Эцсийн дүн

Хичээлийн эрхлэгчийн баталсан шалгалтыг авна.

Энэ шалгалтаар 30% авах бөгөөд улиралын турш үзсэн сэдвүүд хамаарна.



Кредитийг орлуулах

Өөр сургуулиас УАС-д шилжин ирж байгаа сурагчдад дараах зүйлүүдийг үндэслэн орлуулан өгнө.

1. Өмнөх сургуулийн сурлагын дүнг хичээлийн эрхлэгчийн үнэлгээ
2. Элсэлтийн шалгалт
3. Нас

Шилжүүлэх кредитийг тухайн хичээлийн нэрний дор “Тэнцэх Кредит” хэмээн дүнгийн хавсралтад бүртгэж, авсан оноог нь “EQV” гэж тэмдэглэнэ.



Гэрийн даалгавар

Гэрийн даалгаврыг шинэ хичээл, чадварыг гэртээ давтах, санаандаа х үртэл ажлаа гүйцэтгэх, суралцах зуршилтай болоход нь тустай байдаг. Сурагчдын гэрийн даалгавраа хийхэд зарцуулах цаг тухайн сурагчийн оюуны чадавхи, хичээл зүтгэл бас тухайн ангийн түвшин, сургалтын хөтөлбөрөөс шалтгаалан тухай бүр өөр өөр байдаг. Гэхдээ сурах, ямар нэг зүйлийг бүтээх, сайн зуршилтай болоход нь хүүхдээ үргэлж урамшуулж, дэмжиж байгаасай гэж эцэг эх бүхнээс хүсэх байна. Тэгвэл та тэдэнд хэрхэн тусалж болох вэ?

- Хүүхэдтэйгээ юу үзэж байгаа талаар асууж ярилцах
- Орой бүр гэрийн даалгавар хийх нарийн цагийн хуваарь гаргах
- Даалгавраа хийх чимээгүй газар бэлтгэх
- Асуултанд хариулах цаг хүүхдэдээ гаргах